



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нөмрөг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улиастай сум  
2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Аудитор : Г.Уранбаяр

Утас:95183025

Цахим хаяг:[gonchigdorjuranbayr@gmail.com](mailto:gonchigdorjuranbayr@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	<u>4</u>
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	<u>5</u>
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	<u>6</u>
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	<u>7</u>
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	16

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 121  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НӨМРӨГ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
Ж.ДАРМААНЯМ-Д

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нөмрөг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нөмрөг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нөмрөг сумын Эрүүл мэндийн төв нь төсвийн хөрөнгөөр 3.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, 68.5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна. Тайлант хугацаанд нийт 107.2 сая төгрөгийн материал бэлтгэж, 144.2 сая төгрөгийн материал үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Нөмрөг сумын эрүүл мэндийн төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, жолоочийн тооцоо бодоогүй, шатахуун зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа буруу бүртгэсэн, бараа материалын жилийн эцсийн тооллого хийж гүйцэтгээгүй зэрэг алдаа илэрсэн байна.

013020212

Audit(D)Дүгнэлт/2024

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *D. Bat* Д.БАТ-УНДРАА



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>72,881,983.45</u></b>	<b><u>71,310,561.88</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	13,522,767.05	29,072,954.16
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	13,522,767.05	29,072,954.16
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	13,522,767.05	29,072,954.16
31211	Төрийн сангийн харилцах	13,522,767.05	29,072,954.16
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	381,024.90	11,248,994.90
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	381,024.90	381,024.90
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	10,867,970.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	58,978,191.50	30,988,612.82
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	26,871,201.51	9,368,171.97
35110	Тусгай зориулалттай материал	9,783,691.97	8,376,341.97
35130	Эм боох материал	17,087,509.54	991,830.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	31,306,989.99	21,620,440.85
35410	Бичиг хэргийн материал	13,900.00	125,000.00
35420	Аж ахуйн материал	16,454,161.49	15,185,201.35
35430	Сэлбэг хэрэгсэл	2,155,000.00	2,595,000.00
35440	Түлш, шатах тослох материал	512,500.00	467,929.00
35460	Хүнсний материал	4,824,200.50	2,193,310.50
35470	Бусад хангамжийн материал	7,347,228.00	1,054,000.00
35600	Мал амьтад	800,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>975,225,996.38</u></b>	<b><u>1,000,392,428.76</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	975,225,996.38	1,000,392,428.76
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	965,953,996.38	991,120,428.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	936,028,187.00	936,028,187.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(85,817,153.76)	(111,453,386.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,731,428.60	61,731,428.60
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,031,428.56)	(22,531,428.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	140,361,576.75	197,091,067.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(75,288,690.57)	(89,382,329.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,804,708.44	39,654,708.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,664,631.25)	(24,367,819.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,921,600.00	14,521,602.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,261,600.27)	(10,341,600.31)
39217	Ном	170,000.00	170,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,272,000.00	9,272,000.00
39301	Програм хангамж	1,082,540.00	1,082,540.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,082,540.00)	(1,082,540.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,272,000.00	9,272,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,048,107,979.83</u></b>	<b><u>1,071,702,990.64</u></b>

<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,825,200.00</b>	<b>1,825,200.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,825,200.00	1,825,200.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,825,200.00	1,825,200.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,825,200.00	1,825,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,825,200.00	1,825,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,046,282,779.83</b>	<b>1,069,877,790.64</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,046,282,779.83	1,069,877,790.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	437,905,838.20	437,905,838.20
51101	Өмч: - төрийн	437,905,838.20	437,905,838.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	87,606,735.00	111,201,745.81
51210	Өмнөх үеийн үр дүн	(53,308,253.97)	87,606,735.00
51220	Тайлант үеийн үр дүн	140,914,988.97	23,595,010.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	520,770,206.63	520,770,206.63
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,048,107,979.83</b>	<b>1,071,702,990.64</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>653,418,687.28</b>	<b>606,680,314.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>195,266,597.28</b>	<b>77,646,293.89</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	195,266,597.28	77,646,293.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,266,597.28	77,646,293.89
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	195,266,597.28	77,646,293.89
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>458,152,090.00</b>	<b>529,034,020.39</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	29,260,100.00	25,315,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,260,100.00	25,315,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	428,891,990.00	503,718,620.39
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	260,084,970.00	498,042,908.39
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,230,320.00	5,675,712.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	150,576,700.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>512,503,698.31</b>	<b>581,893,055.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>512,503,698.31</b>	<b>581,893,055.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	511,513,011.47	581,893,055.52
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	265,539,096.26	306,459,589.23
210101	Үндсэн цалин	180,875,126.74	182,846,649.84
210102	Нэмэгдэл	62,292,601.00	91,222,864.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,935,136.00	3,612,000.00
210104	Урамшуулал	18,436,232.52	28,778,074.40

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,016,975.69	52,799,292.05
210201	Тэтгэврийн даатгал	27,286,660.74	36,064,592.05
210202	Тэтгэмжийн даатгал	3,183,048.50	4,356,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,546,379.22	3,484,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	701,326.15	870,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,299,561.08	8,022,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,269,413.16	21,123,152.05
210301	Гэрэл, цахилгаан	1,564,613.16	3,524,532.05
210302	Түлш, халаалт	24,581,800.00	17,045,820.00
210303	Цэвэр, бохир ус	123,000.00	552,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,622,650.00	38,829,441.00
210401	Бичиг хэрэг	2,530,600.00	3,900,500.00
210402	Тээвэр, шатахуун	19,880,150.00	20,684,571.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,106,800.00	1,035,300.00
210404	Ном, хэвлэл	55,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	247,000.00	9,471,228.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,803,100.00	3,737,842.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	83,932,118.40	70,101,669.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,872,828.90	61,627,779.03
210502	Хоол, хүнс	7,308,239.50	8,473,890.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,751,050.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,119,100.00	23,086,222.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,706,800.00	9,402,122.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,887,300.00	586,100.00
210604	Урсгал засвар	2,525,000.00	13,098,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,412,000.00	5,192,000.00
210702	Дотоод албан томилолт	2,412,000.00	5,192,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	516,400.00	2,155,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210,000.00	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,600.00	60,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,400.00	89,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,400.00	99,000.00
210807	Газрын төлбөр	50,400.00	139,080.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48,600.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	55,000.00	688,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	58,085,257.96	62,146,010.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,599,124.00	15,132,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,486,133.96	47,013,060.16
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	990,686.84	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	990,686.84	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	990,686.84	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>140,914,988.97</b>	<b>24,787,258.76</b>

5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>140,914,988.97</u></b>	<b><u>24,787,258.76</u></b>
---	--------------------------------	------------------------------	-----------------------------

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>492,497,890.00</u></b>	<b><u>518,166,050.39</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>492,497,890.00</b>	<b>518,166,050.39</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	29,260,100.00	25,315,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,260,100.00	25,315,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	463,237,790.00	492,850,650.39
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	294,430,770.00	487,174,938.39
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,230,320.00	5,675,712.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	150,576,700.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>458,978,422.95</u></b>	<b><u>497,823,613.33</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>458,978,422.95</b>	<b>497,823,613.33</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>457,987,736.11</b>	<b>497,823,613.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	265,539,096.26	306,459,589.23
210101	Үндсэн цалин	180,875,126.74	182,846,649.84
210102	Нэмэгдэл	62,292,601.00	91,222,864.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,935,136.00	3,612,000.00
210104	Урамшуулал	18,436,232.52	28,778,074.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,016,975.69	52,799,292.05
210201	Тэтгэврийн даатгал	27,286,660.74	36,064,592.05
210202	Тэтгэмжийн даатгал	3,183,048.50	4,356,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,546,379.22	3,484,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	701,326.15	870,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,299,561.08	8,022,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,269,413.16	21,123,152.05
210301	Гэрэл, цахилгаан	1,564,613.16	3,524,532.05
210302	Түлш, халаалт	24,581,800.00	17,045,820.00
210303	Цэвэр, бохир ус	123,000.00	552,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,159,400.00	28,642,300.00
210401	Бичиг хэрэг	2,282,000.00	3,230,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,871,000.00	20,640,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,106,800.00	1,035,300.00
210404	Ном, хэвлэл	55,000.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	648,000.00	1,765,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,196,600.00	1,912,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>67,281,527.00</b>	<b>43,957,300.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,510,127.00	36,914,300.00
210502	Хоол, хүнс	8,721,200.00	5,843,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,050,200.00	1,200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,496,100.00</b>	<b>23,847,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,338,800.00	9,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,632,300.00	799,100.00
210604	Урсгал засвар	2,525,000.00	13,848,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,412,000.00</b>	<b>5,192,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,412,000.00	5,192,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>686,400.00</b>	<b>2,352,280.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210,000.00	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,600.00	60,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,400.00	89,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,400.00	99,000.00
210807	Газрын төлбөр	50,400.00	139,080.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	48,600.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	225,000.00	884,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,126,824.00</b>	<b>13,450,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,126,824.00	13,450,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>990,686.84</b>	<b>-</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>990,686.84</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	990,686.84	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>33,519,467.05</b>	<b>20,342,437.06</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>20,000,000.00</b>	<b>3,600,002.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>20,000,000.00</b>	<b>3,600,002.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>20,000,000.00</b>	<b>3,600,002.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,000,000.00	3,600,002.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(20,000,000.00)</b>	<b>(3,600,002.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>13,519,467.05</b>	<b>16,742,435.06</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,300.00</b>	<b>13,522,767.05</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>13,522,767.05</b>	<b>29,072,954.16</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	437,905,838.20	520,770,206.63	(53,308,253.97)	905,367,790.86
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	437,905,838.20	520,770,206.63	(53,308,253.97)	905,367,790.86
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	140,914,988.97	140,914,988.97
C08	2022 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	437,905,838.20	520,770,206.63	87,606,735.00	1,046,282,779.83
D01	2022 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	437,905,838.20	520,770,206.63	87,606,735.00	1,046,282,779.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	437,905,838.20	520,770,206.63	87,606,735.00	1,046,282,779.83
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	23,595,010.81	23,595,010.81
D09	2023 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	437,905,838.20	520,770,206.63	111,201,745.81	1,069,877,790.64

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	626,892,600.00	477,300,463.28
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	626,892,600.00	477,300,463.28
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	626,892,600.00	477,300,463.28
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	450,550,100.00	306,459,589.23
210101	Үндсэн цалин	266,374,800.00	182,846,649.84
210102	Нэмэгдэл	159,559,300.00	91,222,864.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,016,000.00	3,612,000.00
210104	Урамшуулал	19,600,000.00	28,778,074.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	56,318,800.00	52,799,292.05
210201	Тэтгэврийн даатгал	38,296,800.00	36,064,592.05
210202	Тэтгэмжийн даатгал	4,505,500.00	4,356,900.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,604,400.00	3,484,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	901,100.00	870,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,011,000.00	8,022,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,015,000.00</b>	<b>28,642,300.00</b>
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	3,230,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,919,700.00	20,640,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,035,300.00	1,035,300.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,765,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	1,912,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>44,357,300.00</b>	<b>43,957,300.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,914,300.00	36,914,300.00
210502	Хоол, хүнс	6,243,000.00	5,843,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,500,000.00</b>	<b>24,447,102.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,200,000.00	9,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	799,100.00
210604	Урсгал засвар	14,500,000.00	14,448,002.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,220,000.00</b>	<b>5,192,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	5,220,000.00	-
210702	Дотоод албан томилолт	-	5,192,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,471,700.00</b>	<b>2,352,280.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	60,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,000.00	89,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	140,000.00	139,080.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	884,700.00	884,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,459,700.00</b>	<b>13,450,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,459,700.00	13,450,600.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>613,369,800.00</b>	<b>-</b>
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>613,369,800.00</b>	<b>-</b>
122001	Хандив тусламж /дотоод/	613,369,800.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>13,522,767.05</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>29,072,954.16</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нөмрөг сумын Эрүүл мэндийн төв нь “Эрдэнэт хүний эрүүл мэнд -Эх орны баялаг” уриатай ажиллаж байна.

**Эрхэм зорилго:** Анхан шатны эмнэлгийн тусламжийг үйлчлүүлэгчийн хэрэгцээ, мэргэжлийн стандартад нийцүүлэн аюулгүй тав тухтай орчинд, тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Сумын Эрүүл мэндийн төвийн дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор, дотоод хяналтын нэгж байхгүй байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нөмрөг сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нөмрөг сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 23,595.0 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна.

#### **Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	58,978.2	30,988.6	(27,989.6)
Үндсэн хөрөнгө	1,787,372.0	1,000,392.4	(786,979.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,048,108.0</b>	<b>1,071,703.0</b>	<b>23,595.0</b>
Өр төлбөр	1,825.20	1,825.20	--

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,046,282.8	1,069,877.8	23,595.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,048,108.0</b>	<b>1,071,703.0</b>	<b>23,595.0</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 58,978.2 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 107,211.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 9,066.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 144,267.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 30,988.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 27,989.58 мянган төгрөгөөр буурсан байна. Акталсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 3,600.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 68,579.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, актласан үндсэн хөрөнгө байхгүй байна. Жилийн эцэст 1,071,703.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй, тайлант оны элэгдлийн зардалд 47,013.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 23,595.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

#### 5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

##### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 588,054.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 25,315.4 мянган төгрөг, нийт зарлагыг 613,369.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 588,054.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 477,165.2 мянган төгрөг буюу 83.3 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
<b>71602</b>	<b>Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>				
80302	Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон	371,748.0	240,476.0	131,272.3	65%
81603	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	241,622.0	236,689.1	4,932.4	98%
83603	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	13,523.0	135.0	13,387.5	1%
<b>НИЙТ</b>		<b>613,369.8</b>	<b>477,165.2</b>	<b>136,205.0</b>	<b>83.3%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй байдаг ба нэмэлт санхүүжилтээр 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг санхүүжүүлж 25,315.4 мянган төгрөгийг тогтмол зардалд зарцуулсан байна.

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
<b>Тогтмол зардал</b>		25,315.4	25,315.4		100%

### 4. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/Мянган төгрөг/*

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Мах	31,371.30	18,871.50
2	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Хүнсний ногоо	6,445.6	5,420
3	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Сүү, цагаан идээ	12,059.1	7,744.2
4	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – бусад хүнсний материал	22,414.1	23,165.3
5	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Талх, нарийн боов	11,521.8	5,342.5
5	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	51,674	52,969.3
6	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	5,000	3,950.6
7	Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	7,578	6,852
8	Шууд худалдан авалт	Урсгал засвар	8,000	8,000
9	Шууд худалдан авалт	Харилцаа холбооны зардал	1,412.3	1,411.5
10	Шууд худалдан авалт	Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ	2,118.5	2,118.5
<b>ДҮН</b>			<b>161,713.20</b>	<b>137,963.90</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нөмрөг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний

өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Нөмрөг сумын эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Хаан соёмбо аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 16 -ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 298,750.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 4,481.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,361.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Нөмрөг сумын Эрүүл мэндийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,136.0 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж өгч, 755.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, төлбөрийн актыг хугацаанд барагдуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	755.8	1	755.8	100%
Зөвлөмж	1	6,136.0	1	1,867.8	100%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>6,891.8</b>	<b>2</b>	<b>4,186.1</b>	<b>100%</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудлыг тодохойлоогүй байна.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 47,962.3 мянган төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад залрууллаа.

##### **Залруулсан алдаа**

- 47,962.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авахдаа ашиглах жилийг буруу сонгосон алдааг залрууллаа.

Аудитаар нийт 2,521.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2 заалт зөвлөмж хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,521.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 839.6 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

##### **5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй**

##### **5.2 Албан шаардлага хүргүүлээгүй**

##### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал**

##### **1. Илрүүлэлт:**

- 985.0 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилалаар зарцуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **2. Өгсөн зөвлөмж:**

Түлш шатах тослох материалыг зарцуулахдаа жолоочийн замын хуудсаар тооцоо бодож, анхан шатны баримтын бүрдлийг хангалттай, зохистой бүрдүүлж хэвших;

### **2. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал**

#### **2.1 Илрүүлэлт:**

- 1,536.4 мянган төгрөгийн жолоочийн тооцоо дутуу бодсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- **Өгсөн зөвлөмж:**

Түлш шатах тослох материалыг зарцуулахдаа жолоочийн замын хуудсаар тооцоо бодож, анхан шатны баримтын бүрдлийг хангалттай, зохистой бүрдүүлж хэвших;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа буруу оруулсан	1	47,962.4			1	47,962.4	1	47,962.4				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>47,962.4</b>			<b>1</b>	<b>47,962.4</b>	<b>1</b>	<b>47,962.4</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл


Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зардлыг эдийн засгийн ангилалаар зарцуулаагүй	1	985.0					1	985.0				
Жолоочийн тооцоо дутуу бодсон	1	1,536.4					1	1,536.4				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,521.4</b>					<b>2</b>	<b>2,521.4</b>				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР  Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР  Г.УРАНБАЯР ОГНОО: 2024-02-22